ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2024/05/НА-СТА-ТШ3


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2024 он | Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас: 99013699 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ц.Бадрал<br>Утас:91983443 Цахим хаяг: Badralts@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024.02.24 № 1161

танай ______ -ны № ______ -т

БҮСИЙН ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ П.ГЭРЭЛСҮРЭН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

2023 онд ЭМД-ын санхүүжилтээр 18,214,907.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн санхүүжилт 469,505.8 мянган төгрөг, өөрийн орлого 685,749.5 мянган төгрөг, нийт 18,900,657.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Тайлант онд тус байгууллага 7,119,774.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөн, төлөвлөгөөгөө батлуулснаас 4,804,774,100 төгрөгийн төсөвт өртөгтэй 6 арга хэмжээ цуцлагдаж, 14 тендер зарлаж давхардсан тоогоор 75 аж ахуйн нэгжтэй 4,340,275,332 төгрөгийн гэрээ байгуулсан, 12 арга хэмжээг бүрэн дуусгаж, 2 арга хэмжээ гүйцэтгэлийн шатанд байна.

Томографийн аппарат, тоног төхөөрөмжийн сэлбэг, засварын 345 сая төгрөг аймгийн төсвөөс эрх шилжиж ирсэн байна.

### Аудитын гол асуудал

Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтээр 18,214,907.5 сая

төгрөгийг авч, 2,753,149.2 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч авлагаар бүртгэсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь тайлант онд 9 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 84.5 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,301,186,663.37** | **4,124,591,180.63** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 66,176,718.57 | 86,701,560.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 66,176,718.57 | 86,701,560.00 |
| **3121** | **Төгрөг** | 66,176,718.57 | 86,701,560.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 66,176,718.57 | 86,701,560.00 |
| **33** | **АВЛАГА** | 1,503,478,262.00 | 2,753,149,227.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 3,294,384.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 1,503,478,262.00 | 2,749,854,843.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 731,531,682.80 | 1,284,740,393.63 |
| **351** | **Түүхий эд материал** | 362,010,151.96 | 769,596,236.75 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 94,465,104.03 | 499,395,013.83 |
| 35130 | Эм боох материал | 267,545,047.93 | 270,201,222.92 |
| **354** | **Хангамжийн материал** | 369,521,530.84 | 515,144,156.88 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,046,000.00 | 921,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,942,560.00 | 811,190.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 9,240,650.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,562,718.00 | 1,350,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 12,813,500.00 | 47,068,975.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,433,830.00 | 2,515,601.04 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 341,722,922.84 | 453,236,240.84 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **31,454,029,929.18** | **29,779,797,238.14** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 31,454,029,929.18 | 29,779,797,238.14 |
| **392** | **Биет хөрөнгө** | 30,477,328,932.22 | 28,824,913,051.50 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 15,327,722,824.34 | 15,407,628,692.34 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,785,591,930.91 | -2,260,225,228.14 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 1,125,961,186.00 | 1,324,591,777.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -496,044,199.51 | -605,786,459.23 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 21,521,459,015.83 | 22,255,190,198.43 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -6,336,814,414.49 | -8,516,570,782.85 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 651,051,282.06 | 750,984,782.06 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -157,393,753.88 | -244,043,785.17 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 821,588,574.00 | 1,049,342,074.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -194,875,886.22 | -336,464,451.94 |
| 39217 | Ном | 266,235.00 | 266,235.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 976,700,996.96 | 954,884,186.64 |
| 39301 | Програм хангамж | 213,536,189.00 | 218,805,189.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -53,063,192.04 | -80,149,002.36 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 816,228,000.00 | 816,228,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **33,755,216,592.55** | **33,904,388,418.77** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **3,280,490,238.39** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 3,280,490,238.39 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 3,280,490,238.39 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 1,129,285,542.43 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 2,151,204,695.96 |

| | | | |
|---|---|---|---|
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 2,148,395,445.96 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00.00 | 2,809,250.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **33,755,216,592.55** | **30,623,898,180.38** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 33,755,216,592.55 | **30,623,898,180.38** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 6,876,720,589.00 | 6,876,720,589.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 6,876,720,589.00 | 6,876,720,589.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 19,100,646,920.69 | 15,974,179,508.52 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 19,100,646,920.69 | 19,100,646,920.69 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -3,131,318,412.17 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7,777,849,082.86 | 7,777,849,082.86 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **33,755,216,592.55** | **33,904,388,418.77** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **19,941,544,664.45** | **21,302,193,438.29** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **19,791,501,664.45** | **20,832,687,603.29** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,179,233,496.45 | 1,371,403,484.29 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,179,233,496.45 | 1,371,403,484.29 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 723,132,522.77 | 685,749,457.80 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,787,500.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,454,313,473.68 | 685,654,026.49 |
| **122** | **Тусламжийн орлого** | 17,612,268,168.00 | 19,461,284,119.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 17,612,268,168.00 | 19,461,284,119.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **150,043,000.00** | **469,505,835.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 150,043,000.00 | 469,505,835.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 150,043,000.00 | 400,734,560.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 68,771,275.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **21,921,713,975.23** | **24,433,511,850.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **21,921,713,975.23** | **24,433,511,850.46** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 21,586,944,884.23 | 24,366,883,990.46 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 9,045,716,144.00 | 12,083,194,845.46 |
| 210101 | Үндсэн цалин | 4,675,982,100.00 | 5,356,882,772.56 |
| 210102 | Нэмэгдэл | 3,166,669,899.00 | 5,703,929,086.91 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 296,744,145.00 | 491,032,005.99 |
| 210104 | Урамшуулал | 906,320,000.00 | 531,350,980.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,102,625,415.00 | 1,516,694,383.89 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 798,331,632.39 | 1,021,738,661.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 84,448,177.72 | 124,378,248.25 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 44,713,981.14 | 107,793,350.64 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 16,009,729.78 | 25,538,776.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 159,121,893.97 | 237,245,346.89 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,274,332,036.00 | 1,501,966,375.37 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 223,981,979.00 | 261,723,445.51 |
| 210302 | Түлш, халаалт | 826,278,171.00 | 948,526,849.86 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 224,071,886.00 | 291,716,080.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 324,508,659.00 | 290,716,757.67 |
| 210401 | Бичиг хэрэг | 72,036,865.00 | 66,622,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 242,753,540.00 | 214,550,050.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,604,755.00 | 9,544,057.67 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 113,499.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 5,424,048,068.77 | 4,969,861,285.06 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,014,980,669.77 | 4,531,652,338.10 |
| 210502 | Хоол, хүнс | 409,067,399.00 | 438,208,946.96 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,540,692,108.86 | 882,369,357.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,060,000.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 778,100.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,538,854,008.86 | 882,369,357.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 41,746,000.00 | 37,773,154.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 41,746,000.00 | 37,773,154.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 29,384,049.00 | 56,080,224.37 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 3,750,120.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 9,500,000.00 | 23,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 3,500,000.00 | 7,388,952.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 7,224,049.00 | 3,783,120.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,140,000.00 | 8,607,792.37 |
| 210807 | Газрын төлбөр | 2,020,000.00 | 9,050,240.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,803,892,403.60 | 3,028,227,607.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 8,771,275.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 2,803,892,403.60 | 3,019,456,332.64 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 334,769,091.00 | 66,627,860.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 334,734,091.00 | 66,627,860.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 334,734,091.00 | 66,627,860.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 35,000.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,000.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-1,980,169,310.78** | **-3,131,318,412.17** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-1,980,169,310.78** | **-3,131,318,412.17** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 6,876,720,589.00 | 7,793,037,736.70 | 21,065,627,577.63 | 35,735,385,903.33 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 6,876,720,589.00 | 7,793,037,736.70 | 21,080,816,231.47 | 35,750,574,557.17 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -1,980,169,310.78 | -1,980,169,310.78 |
| C08 | 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 6,876,720,589.00 | 7,777,849,082.86 | 19,100,646,920.69 | 33,755,216,592.55 |
| D01 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 6,876,720,589.00 | 7,777,849,082.86 | 19,100,646,920.69 | 33,755,216,592.55 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 6,876,720,589.00 | 7,777,849,082.86 | 19,100,646,920.69 | 33,755,216,592.55 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -3,131,318,412.17 | -3,131,318,412.17 |
| D09 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 6,876,720,589.00 | 7,777,849,082.86 | 15,969,328,508.52 | 30,623,898,180.38 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **20,595,629,561.57** | **19,370,162,830.80** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **20,445,586,561.57** | **18,900,656,995.80** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 724,920,022.77 | 685,749,457.80 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 724,920,022.77 | 685,749,457.80 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 723,132,522.77 | 685,749,457.80 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,787,500.00 | 00.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 19,720,666,538.80 | 18,214,907,538.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 19,720,666,538.80 | 18,214,907,538.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **150,043,000.00** | **469,505,835.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 150,043,000.00 | 469,505,835.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 150,043,000.00 | 400,734,560.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 68,771,275.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **20,529,452,843.00** | **19,349,637,989.37** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **20,529,452,843.00** | **19,349,637,989.37** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **20,146,688,112.00** | **19,283,010,129.37** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 9,017,710,900.00 | 11,081,743,212.35 |
| 210101 | Үндсэн цалин | 4,675,982,100.00 | 5,363,254,568.57 |
| 210102 | Нэмэгдэл | 3,138,634,655.00 | 4,696,105,657.33 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 296,774,145.00 | 491,032,006.26 |
| 210104 | Урамшуулал | 906,320,000.00 | 531,350,980.19 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,127,580,400.00 | 1,339,367,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 766,754,700.00 | 910,769,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 90,206,400.00 | 107,149,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 72,165,100.00 | 85,719,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,041,300.00 | 21,429,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 180,412,900.00 | 214,298,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,409,120,315.00 | 1,041,698,152.07 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 223,981,979.00 | 236,181,424.13 |
| 210302 | Түлш, халаалт | 946,073,359.00 | 562,253,327.94 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 239,064,977.00 | 243,263,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 365,175,150.00 | 332,905,919.67 |
| 210401 | Бичиг хэрэг | 53,445,350.00 | 28,844,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 214,543,700.00 | 196,525,732.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,894,200.00 | 10,510,397.67 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 56,675,100.00 | 71,476,060.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 30,616,800.00 | 25,548,880.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 5,847,037,864.00 | 3,187,915,705.34 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,383,718,258.00 | 2,728,227,505.34 |
| 210502 | Хоол, хүнс | 410,029,306.00 | 399,705,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 53,290,300.00 | 59,983,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,282,477,044.00 | 2,165,607,986.57 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 413,529,804.00 | 203,644,858.57 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 5,200,000.00 | 5,200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,863,747,240.00 | 1,956,763,128.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 40,000,000.00 | 37,773,154.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 40,000,000.00 | 37,773,154.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 55,798,939.00 | 87,227,224.37 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 3,750,120.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 9,500,000.00 | 23,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 3,500,000.00 | 7,388,952.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 7,224,049.00 | 3,783,120.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,767,508.00 | 8,607,792.37 |
| 210807 | Газрын төлбөр | 2,020,000.00 | 9,050,240.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 2,350,000.00 | 1,250,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 21,437,382.00 | 29,897,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,787,500.00 | 8,771,275.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 8,771,275.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,787,500.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **382,764,731.00** | **66,627,860.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 382,729,731.00 | 66,627,860.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 382,729,731.00 | 66,627,860.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 35,000.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,000.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **66,176,718.57** | **20,524,841.43** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 66,176,718.57 | 20,524,841.43 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 66,176,718.57 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 66,176,718.57 | 86,701,560.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 20,266,391,600.00 | 19,349,637,989.37 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 20,266,391,600.00 | 19,349,637,989.37 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 20,166,391,600.00 | 19,283,010,129.37 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 11,214,334,300.00 | 11,081,743,212.35 |
| 210101 | Үндсэн цалин | 5,316,733,100.00 | 5,363,254,568.57 |
| 210102 | Нэмэгдэл | 4,427,991,100.00 | 4,696,105,657.33 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 450,000,000.00 | 491,032,006.26 |
| 210104 | Урамшуулал | 1,019,610,100.00 | 531,350,980.19 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,335,242,500.00 | 1,339,367,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 907,964,900.00 | 910,769,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 106,819,400.00 | 107,149,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 85,455,500.00 | 85,719,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 21,363,900.00 | 21,429,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 213,638,800.00 | 214,298,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,526,454,200.00 | 1,041,698,152.07 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 302,564,000.00 | 236,181,424.13 |
| 210302 | Түлш, халаалт | 935,677,000.00 | 562,253,327.94 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 288,213,200.00 | 243,263,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 357,621,800.00 | 332,905,919.67 |
| 210401 | Бичиг хэрэг | 36,400,000.00 | 28,844,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 196,525,800.00 | 196,525,732.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,530,000.00 | 10,510,397.67 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 83,550,000.00 | 71,476,060.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 30,616,000.00 | 25,548,880.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,721,574,200.00 | 3,187,915,705.34 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,273,569,000.00 | 2,728,227,505.34 |
| 210502 | Хоол, хүнс | 388,005,200.00 | 399,705,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 60,000,000.00 | 59,983,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,858,051,100.00 | 2,165,607,986.57 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 193,197,500.00 | 203,644,858.57 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 5,200,000.00 | 5,200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,659,653,600.00 | 1,956,763,128.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 42,920,000.00 | 37,773,154.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 42,920,000.00 | 37,773,154.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 110,193,500.00 | 87,227,224.37 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 4,673,000.00 | 3,750,120.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 23,500,000.00 | 23,500,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 7,500,000.00 | 7,388,952.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 4,000,000.00 | 3,783,120.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 15,000,000.00 | 8,607,792.37 |
| 210807 | Газрын төлбөр | 9,424,000.00 | 9,050,240.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 2,350,000.00 | 1,250,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 43,746,500.00 | 29,897,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 8,771,275.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 8,771,275.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 100,000,000.00 | 66,627,860.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 100,000,000.00 | 66,627,860.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 100,000,000.00 | 66,627,860.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 20,266,391,600.00 | 19,370,162,830.80 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,898,236,300.00 | 685,749,457.80 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,380,525,300.00 | 685,749,457.80 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 451,534,200.00 | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 66,176,800.00 | - |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 18,368,155,300.00 | 18,214,907,538.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 18,368,155,300.00 | 18,214,907,538.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 66,176,718.57 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 86,701,560.00 |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 151,144.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 128,774.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа[1]-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулагдаагүй нийт 22.369.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 22,369.5 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 9.715.9 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 12,653.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөрчил арилгуулах албан шаардлага, 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

1. Нууц хамгаалах ажилтны шалгалтад хамрагдаж, эрх аваагүй нэр бүхий 8 ажилтанд нууцын нэмэгдэлд 6.24.209 төгрөг олгосон нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7-д "Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтан /цаашид "нууц хамгаалах ажилтан" гэх/ гэж төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд төрийн болон албаны нууцын хамгаалалтыг зохион байгуулж хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий нэгжийн ажилтан, эсхүл энэ чиг үүргийг хэрэгжүүлэх ажилтныг;" Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 1.2-д "Нууц хамгаалах ажилтнаар тагнуулын байгууллагын Аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж тэнцсэн

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглэээгүй орхисон/,*

[2] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

хүнийг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилно." 4.1-д "Нууц хамгаалах ажилтнаас бусад нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдэл олгохыг хориглоно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2. 2023 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулж санхүүжилт олгохдоо Өдрийн эмчилгээний байрны засварын ажлын гүйцэтгэгчид 3,468,740 төгрөгийн захиалагчийн мэдлийн зардлууд буюу захиалагчийн хяналтын, зохиогчийн хяналтын, магадалшгүй ажлын зардлуудыг гүйцэтгэгч компанид илүү тооцон олгосон нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.7-д “Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагдсан байх бөгөөд зардлыг зориулалтын дагуу ашиглана.”, Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм /БНбД 81-94-12/”-ийн 4.11-д “Захиалагчийн мэдлийн зардал нь газрыг ашиглах, эзэмших, өмчлөхтэй холбогдсон зардал, инженерийн хайгуул, зураг төслийн зардал, захиалагчийн хяналтын зардал, зөвлөх үйлчилгээ, тохируулга, зүгшрүүлэлт, магадалшгүй ажил зэргээс бүрдэнэ. Эдгээр зардал нь захиалагчийн мэдэлд байх бөгөөд гүйцэтгэл зардлыг үндэслэн холбогдох тооцоог хийнэ.”, Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 4.3.8-д ”Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, гэрээний нийт дүнд багтсан зардлуудаас доор дурдсан зардлын зориулалт, зарцуулалтыг дараах байдлаар удирдамж болгоно:”, 4.9-д “Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь хэрэгжиж дууссан, ашиглалтад орсонтой холбогдуулан энэ журмын 4.3.8-д заасан зардлаас зарцуулагдаагүй үлдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлнэ гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

### 3.2 Албан шаардлага

1. Ёс зүйн хорооны нэр бүхий гишүүдэд захирлын Б/16 дугаар тушаалаар сар бүр урамшуулал олгохоор шийдвэрлэж 2023 онд 12,653,576 төгрөг олгосон нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/256 дугаар тушаалын хавсралтын 6.2-д "хорооны гишүүдэд хурлын ирц, ажил үүргийн хуваарийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлийг харгалзан улирал тутам урамшуулал олгоно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал***

***Илрүүлэлт:***
Худалдан авах ажиллагаа зохион байгуулж санхүүжилт олгохдоо анхан шатны баримт, гүйцэтгэлийн баримтуудад үндэслэн санхүүжилт олгоогүй нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 4.3-д заасан “Гүйцэтгэлийн санхүүжилт, түүний ангилал, бүрдүүлэх материал:”-ын жагсаалтад заасан 4.3.4-д заасан эхний, 4.3.5-д заасан дундын, 4.3.6-д заасан эцсийн санхүүжилт олгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах

үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журмыг мөрдөж ажиллах.

### 2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

***Илрүүлэлт:***

Худалдан авах ажиллагаа зохион байгуулж ажил гүйцэтгүүлж гэрээ байгуулахдаа гэрээнд болон тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгааг тусгаагүй, санхүүжилтээс баталгааг авч үлдээгүй байгаа нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журмын 4.2.2.5-д "Төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх;", 4.2.2.6-д "Чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг гүйцэтгэл тус бүрээс, эсхүл эцсийн буюу бүрэн санхүүжилтээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу суутган барьцаа хөрөнгийн дансанд байршуулах асуудлыг тухайн төсөл, арга хэмжээний гэрээний тусгай нөхцөлд тусгасан байх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журам, Барилгын тухай хуулийн дагуу барилга байгууламж, засвар үйлчилгээний ажлуудын гэрээнд баталгаат хугацаа, барьцаан зайлшгүй тусган тооцож ажиллах.

### 3. Цалин хөлстэй холбоотой асуудал

***Илрүүлэлт:***

Ур чадварын нэмэгдлийг олгохдоо ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнээгүй, шалгуур үзүүлэлт хангасан эсэхийг тооцоогүй спортын тэмцээнд амжилт үзүүлсэн гэх мэтэд үндэслэн олгож байгаа нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 3-д "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.", хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, сангийн сайдын хамтарсан 63/104 дүгээр тушаалын хавсралтын 2-д "Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг буюу бусдаас илүү идэвх санаачилга, өндөр үр дүнтэй ажиллаж байгаа түгээмэл мэргэжлийн албан хаагчдад дараах үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан ур чадварын нэмэгдэл олгоно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлт хангасан, үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтнуудад ажлын гүйцэтгэлийг харгалзан олгох.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл* */мянган төгрөгөөр/*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| БОЭТ | ЭМГ, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийг данс бүртгэлд дутуу тусгасан | 1 | 30,081.1 | 1 | 30,081.1 | | | 1 | 30,081.1 | | | | |
| | ЭМГ, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар ирсэн Эмнэлгийн хэрэгслийг данс бүртгэлд дутуу тусгасан | 1 | 98,693.4 | 1 | 98,693.4 | | | 1 | 98,693.4 | | | | |
| | | **2** | **128,774.5** | **2** | **128,774.5** | | | **2** | **128,774.5** | | | | |

*4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл* */мянган төгрөгөөр/*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| БОЭТ | Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал | 1 | 3,468.7 | 1 | 3,468.7 | | | | | | |
| | Цалин хөлс илүү тооцон олгосон. | 1 | 6.247.2 | 1 | 6.247.2 | | | | | | |
| | Ёс зүйн урамшууллыг гүйцэтгэлээр бус сар бүр олгосон. | 1 | 12,653.6 | | | 1 | 12,653.6 | | | | |
| | Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлт тооцолгүй олгосон | 1 | - | | | | | 1 | - | | |
| | Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал | 2 | - | | | | | 2 | - | | |
| **ДҮН** | | **6** | **22,369.5** | **2** | **9,715.9** | **1** | 12,653.6 | **3** | **-** | | |

## ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |